



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/37/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Дархан-Уул аймаг
2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: **С.Батцэцэг**

Утас: **7037-3089**

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Дундманхайдай аудит”

ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Утас: 91991462

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

ДАРХАН СУМЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ О.ЧИМЭДЦЭРЭН
ТАНАА

2022.02.25 № 151
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан сумын 12 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан сумын 12 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАР ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯР



009020230

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/мянган төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	<u>72,816,972.90</u>	<u>74,811,131.30</u>
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	<u>1,651,384,880.40</u>	<u>1,592,225,667.67</u>
	Нийт хөрөнгийн дүн	<u>1,724,201,853.30</u>	<u>1,667,036,798.97</u>
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>1,724,201,853.30</u>	<u>1,667,036,798.97</u>
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>1,724,201,853.30</u>	<u>1,667,036,798.97</u>
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	860,506,614.49	955,174,592.19
	Үйл ажиллагааны зардлын дүн	901,273,250.49	1,001,506,070.15
	Үйл ажиллагааны үр дүн	<u>(40,766,636.00)</u>	<u>(46,331,477.96)</u>
	Үйл ажиллагааны бус үр дүн	(1,205,832.95)	(10,833,576.37)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	<u>(41,972,468.95)</u>	<u>(57,165,054.33)</u>
			(41,972,468.95)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,769,874,322.25	1,799,919,806.50
	Тайлант оны үр дүн	(41,972,468.95)	(57,165,054.33)
	Эцсийн үлдэгдэл	1,724,201,853.30	1,667,036,798.97
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	<u>811,360,456.00</u>	<u>940,558,124.80</u>
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	<u>808,160,456.00</u>	<u>936,908,124.80</u>
	Үйл ажиллагааны ЦМГ	<u>3,200,000.00</u>	<u>3,650,000.00</u>
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	-	-
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	937,691,300.00	916,159,154.81
	Урсгал зардал	937,691,300.00	916,159,154.81
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	51,853,000.00	931,877,473.00
	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	885,838,300.00
	Орон нутгийн төсвөөс	51,853,000.00	46,039,173.00
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын Ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн тайлант хугацаанд дэвшүүлсэн зорилго, зорилт, түүний хэрэгжилтийн талаарх товч мэдээлэл:

ЭРХЭМ ЗОРИЛГО: Боловсролын тэгш хамран сургалтыг сайжруулж, өөртөө итгэлтэй, зөв хүмүүжилтэй иргэнийг төлөвшүүлэн бүхнийг хүүхдийн төлөө зориулна.

ЗОРИЛГО: “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын Засгийн газар, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, БШУ-ны яам болон БСУГ-ын боловсролын талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд оршино. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна:

- Сургуулийн удирдлага менежментийг сайжруулах
- Сургуулийн үнэлгээний системийг боловсронгуй болгож, хөндлөнгийн үнэлгээний тогтолцоог буй болгох
- Сургалтын чанарт ахиц гаргах
- Суралцагчдын тэгш хамран сурах нөхцөлийн сайжруулах
- “Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль”-ийг хэрэгжүүлэх
- Дунд, ахлах ангийн сурагчдын сурах бичиг, дүрэмт хувцасны хүртээмжийг нэмэгдүүлэх
- Цахим онлайн системийг буй болгох
- Дотуур байрны хүүхдийн хоол хүнсний аюулгүй байдлыг хангах
- АУБ нар хүүхдийн хөгжил, хүмүүжил төлөвшлийн асуудлаар эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөн туслах ажлыг тогтмолжуулах
- Сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх
- СӨБ-ын хамтын ажиллагааг өргөжүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол

Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол

Сангийн сайдын 2021 оны 190 тус тус шинээр мөрдөгдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд ашиглаж байгаа боловч үлдэх өртөггүй 189,767.8 мянган төгрөгийн 91 нэр төрлийн хөрөнгө болон улсын бүртгэлийн гэрчилгээнд 914,115.1 мянган төгрөгөөр дүрмийн санг нэмэгдүүлж холбогдох байгууллагуудад хүсэлт гаргаж шийдвэрлүүлсэн байдалд дараагийн аудитаар хяналтыг хэрэгжүүлнэ.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1,970.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 49.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,920.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

1. Тайлант хугацаанд хөдөлмөр эрхэлдэг 25 албан хаагчид нийт 49,994.53 төгрөгийн ХХОАТ-ын ногдох хөнгөлөлтийг буруу тооцож дутуу суутган, гарт олгох цалинг илүү олгосон нь: ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараахь хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ:" гэсэн заалт, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.
2. Тайлант хугацааны татвар төлөлтийн тайланг тулган шалгахад 2021 онд 1,715,261.97 төгрөгөөр дутуу төлөлтийг санхүүгийн тайланд тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэсэн тус тус заалт, "Тасалбар болголт" батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.
3. Шаардах хуудсаар тавьж олгосон 85,200.00 төгрөгийн цахилгаан хэрэгсэл тоо ширхэг засвартай, нотломж, зарцуулалтын тайлан тайлагнаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалт, "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдэлтэй нийцээгүй зөвлөмж өгөх
4. Тайлант хугацаанд 7 албан хаагчид нийт 74,003.64 төгрөгийн ХХОАТ-ыг илүү суутгаж, гарт олгох цалинг дутуу олгосон нь: ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ гэсэнтэй нийцэхгүй байна.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	4	1,970.4	-	-	1	49.9	-	-	3	1,920.5
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	4	1,970.4	-	-	1	49.9	-	-	3	1,920.5



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

Дугаар 37/5510526/2022-2022/17/11А-ОА-ТМБ Дархан сум

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд 25 албан хаагчид нийт 49,994.53 /Дөчин есөн мянга есөн зуун ерэн дөрвөн төгрөг 53 мөнгө/ төгрөгийн ХХОАТ-ын ногдох хөнгөлөлтийг буруу тооцож дутуу суутган, гарт олгох цалинг илүү олгосон байна.

Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараахь хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ:" гэсэнтэй нийцэхгүй байна. Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийг мөрдөн ХХОАТ-ын хөнгөлөлтийг давхардуулан тооцохгүй байх, төлбөрийн акт тогтоох

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.3.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тайлант хугацаанд 25 албан хаагчид нийт 49,994.53 /Дөчин есөн мянга есөн зуун ерэн дөрвөн төгрөг 53 мөнгө/ төгрөгийн ХХОАТ-ын ногдох хөнгөлөлтийг буруу тооцож дутуу суутган, гарт олгох цалинг илүү олгосон зөрчлийг Нягтлан бодогч Б.Одсайханаар төлүүлж, Төрийн сан банкин дахь Даа.Хүү, торгуулийн орлогын 100190000988 тоот дансанд төвлөрүүлэх,

2. Актын биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор төлүүлж Дархан - Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар сургуулийн захирал О.Чимэдцэрэн, Нягтлан бодогч Б.Одсайхан нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР  Ж.БЯМБАЖАВ

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯР

009050126